

The Premium House.



Энэхүү барилга нь өвөрмөц тогтоц бүхий өндөрлөг хэсэгт орчныхоо өнгө төрхтэй уусаж байгалийн нэг хэсэг мэт оршино. “Бид орон зайд ордог, орон зай бидэнд ордог ба энэ нь объектив болон субъектив нэгдлийн солилцоог мэдрүүлдэг”. Барилга дотроосоо байгалийн үзэсгэлэнг тольдох өргөн харууцтай төдийгүй өөрийн оршин буйгаа мэдрэх боломжийг бүрдүүлсэн хувийн орон зайтай байхаар төлөвлөлтийг боловсруулав.


BIM Implementation

BIM бол дан ганц программ хангамжийн шийдэл биш бөгөөд технологи, хамтын ажиллагааг сууриа болгосон процесс юм. BIM-ийг хэрэгжүүлэхийн тулд “уламжлалт” төслийн үйл явцтай харьцуулахад суурь өөрчлөлт гаргахыг шаарддаг.





MacLeamy curvy буюу “хүчин чармайлтг шилжүүлэх” муруй нь зураг төслийн үйл явц цааш явах тусам аливаа өөрчлөлтийн зардал өндөр болно гэдгийг онцлон харуулдаг диаграмм юм. Энэ нь мөн өөрчлөлтийн зардлаас гадна төслийн саатал, алдагдал, нийлүүлэлтийн зардал өсөхтэй шууд хамааралтай.

BIM нь оролцогч талуудад дизайны хувилбаруудыг судлах, эрчим хүчний гүйцэтгэлийг загварчлах, дүн шинжилгээ хийх, урт хугацааны үйл ажиллагааны зардлыг үнэлэх боломжийг олгодог. Ингэснээр зардлаа хэмнэх боломжуудыг зураг төслийн процессын эхэн үед тодорхойлж, хэрэгжүүлэх боломжтой.

BIM-ийн дүрслэл, загварчлалын чадвар нь оролцогч талуудад дизайныг оновчтой болгох, ирээдүйд гарах өөрчлөлтийн багасгах, зардлын үр ашгийг дээшлүүлэх боломжийг олгодог.




Эх сурвалж: thenbs.com/knowledge/bim-implementation-hok-buildingsmart



Архитектор, инженерүүдэд зориулсан **Building Information modeling - BIM** дэмжигч дизайн хэрэгтэй нэгдсэн нэг мэдээллийн сан болох **Autodesk Revit** программын

тусламжтай барилгын иж бүрэн зураг төслийг 100% хийж гүйцэтгэсэн дараах Улаанбаатар хотод баригдаж буй өндөр барилгын төслийн хэсгээс танилцуулж байна.



Азийн архитектурын өвд бүртгүүлсэн барилга. Архитектор Б.Дамбийням “Үйлдвэр хоршооллын худалдаа үйлчилгээний нэгдсэн төв барилга” 1957-1961он


УРТ ЦАГААН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ



Нийслэлийн өмчийн III байр буюу “Урт Цагаан” үйлчилгээний төвийн барилгын дахин төлөвлөлт концепц загвар зураг төсөл боловсруулах уралдааны “ТЭРГҮҮН БАЙР”.

“Урт цагаан” үйлчилгээний төвийг дахин төлөвлөх ажлын концепц санаагаараа:


01. Машингүй гудамж санааг эргэн авчрах.
02. Бидний дунд алдаршсан “Урт цагаан” нэрийг авч үлдэх.
03. Улаанбаатар хотын барилгажилтын 3 үеийн түүхийг шингээхийг зорьсон.
04. Үндсэн барилгын зориулалтыг алдагдуулахгүйгээр залуусын нийгмийн оролцоог дэмжих залуучуудын төв болгох.



ENCANTO CENTRO



ОГТЛОЛ




БАРИЛГЫН НЭР: “Камдер” ХХК орон сууцны цогцолбор хотхон
БАЙРШИЛ: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо
ЗОРИУЛАЛТ: Олон зориулалттай орон сууц
ДАВХРЫН ТОО: 25 давхар

АРХИТЕКТУР: MGL E&C барилга архитектурын баг
БАРИЛГА БҮТЭЭЦ: MGL E&C барилга бүтээцийн баг
ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ: MGL E&C инженерийн шугам сүлжээний /MEP/ баг

2022 он


ПАНДУС




СИНТЕТИК ГУЛГУУРЫН ТАЛБАЙ



ХЭСЭГЛЭЛ




НИСДЭГ ТЭРЭГНИЙ ЗОГСООЛ



Энэхүү буландаа бид уншигчдадаа аль болох бодит байдлыг хүргэхийг зорин архитектур мэргэжлээр ажиллаж буй тэдний адал явдал, түүх, үзэл бодол, хуримтлуулсан туршлагын тухай нийтлэлийг бэлтгэлээ.

Мэргэжлээрээ 6 дэх жилдээ ажиллаж байгаа, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Архитектурын ангийн төгсөгч, MGL E&C компанийн **архитектор Г.Дашиям**-тай ажлын гараа, мэргэжил сонголт, ажиллах арга барилын тухай цомхон яриа өрнүүллээ.



ЯРИЛЦ – ЛАГА

Одоо та ямар төсөл дээр ажиллаж байгаа вэ?

Үйлдвэрийн төсөл дээр ажиллаж байгаа. Ихэвчлэн концепц эскиз дээр ажилладаг. Одоо ажлын зураг зураад баг хамт олноосоо их юм сурч байгаа.

Төгсөөд ажиллаж эхлэхэд ямар байсан бэ?

Анх 3-р курсээсээ ажиллаж эхэлсэн. Их хэцүү санагдаж байлаа. Ярилцлагад ороход сэдвээ өгөөд шууд гар эскиз хийлгээд, зураад үзүүлсэн чинь шууд модельд гэж байсан. Тэр газраа анх програмуудаас эхлээд олон зүйлийг сурч байлаа. Өмнө нь зургийн суурьтай байсан болохоор концепц хийх дөхөм байсан юм шиг санагддаг.

Ямар арга барилаар концепцоо хийдэг вэ?

Коллежид зургийн ангид сурч байхад зохиомж гэж хичээл ордог. Ямар ч хамаагүй нэг сэдэв өгөөд тэр сэдвийг зургаар илэрхийлнэ. Эхэндээ ойлгомжгүй их хэцүү санагдаж байсан. Багш тэгэхэд **“Байгаа зүйлээс байхгүй үүсдэг. Эргэн тойрноо ажигла дүүрэн зохиомжийн сэдэв байгаа.”** гэж хэлж байлаа. Энэ өгүүлбэр надад гүн тусаж тэрнээс хойш би эргэн тойрноо ажиглаж зохиомж эрж хайж явдаг болсон. Сүүлдээ зуршил болоод юм болгоныг хараад энэ зохиомжийн төв нь байна, эргэн тойрон нь нийм байвал төв нь тодрох юм байна гээд зохиомжилж хардаг болсон байсан. Их сургуульд ороод миний

зохиомжийн сэдэв нь **барилга** болчихсон. Ийм арга барилаар анхны санаагаа гаргадаг. Мэдээж хүн хүн өөр, янз янзаар л санаагаа гаргадаг.

Яагаад архитектор болохоор шийдсэн бэ, яагаад зураач болоогүй вэ?

Зургийн ангийн дипломоо хамгаалсны дараа ангиараа тойрч суугаад ярилцаж байгаад багш биднээс төгсөөд юу хийх вэ, ямар сургуульд орох вэ гээд хүүхэд бүрээс асууж байсан юм. Надад төлөвлөгөө байгаагүй. Өмнөх хүүхдийн хариултаас санаа аваад юм бодолгүй ШУТИС-д архитектурын ангид ордог юм уу гэж бодож байгаа гэхэд “Чи чадах уу?” гэж хэлж байсан. Тэгж хэлснийх нь дараа сургалтанд явж байгаад их сургуульд орж чадсан. Одоо багшдаа их баярладаг, сүүлд баярлалаа гээд хэлсэн. Тухайн үед намайг чадахгүй л гэж бодсон юм шиг байгаа юм.

Мэргэжилдээ дуртай байхын талаар ярь.

Миний энэ мэргэжилдээ дуртай байхын нэг шалтгаан нь өмнө нь зургийн ангид байхад зургаа зураад л байх тусам гоё болоод байдаг, дээрээс нь зургаа дууссаны дараа харахад үнэхээр кайфтай мэдрэмж авдаг байлаа. Ерөнхий санааг нь гаргаад явж байтал сүүлдээ гоё болоод байгааг нь харах түүнтэй яг

адилхан. Бусад архитекторууддаа хэлэхэд хийж байгаа юмныхаа **ҮЙЛ ЯВЦА**ас кайф авч байгаарай гэж хэлье.

Хүндрэлтэй зүйл байдаг уу?

Хүндрэлтэй зүйл бараг байхгүй. Концепц хийсээр байгаад гарт ороод, сүүлдээ уйдаад эхэлж байхад ажлын зураг хийж эхлээд, шинэ юм сурч байгаа болохоор сонирхолтой байгаа. Ажлын зураг зурж байхдаа жижиг деталиудыг хараад, цэвэрхэн гоё болж байгааг харах дуртай.





Миний хувьд хийж байгаа зураг минь баригдах баригдахгүй нь асуудал биш. Уран зургаар бол би зургаа зурчаж байгаа юм. Тэрийг галлерид өлгөх өлгөхгүй нь дараагийн асуудал. Энэ баригдахгүй байсан ч надад байж л байгаа. Түүнээс цааш олон асуудал байгаа учраас тэрэнд анхаарлаа хандуулдаггүй.

Концепцоо хийж байгаад өөр юм бодогдонгуут хажууд нь хуулж тавиад санаагаа тусгаад явдаг. Надад таалагдсан мөртлөө захиалагчид таалагдаагүй хувилбарууд зөндөө. Гэхдээ өмнө нь хийж байсан санаанууд дараа дараагийнхаа төсөл дээр хэрэг болоод л явдаг. Батлагдаагүй хувилбаруудаа эргэж хараад, өмнөх

санаануудаа сайжруулдаг ч юм уу бүгд л **туршлага** болоод явна. Захиалагч бол мэдээж өртөг, ашиглалт харна.

Чөлөөт цагаараа юу хийж байна вэ?

Чөлөөт цагаараа зураг зурмаар байна. Ямар хэмжээтэй, яаж зурах, иймэрхүү сэдвээр гээд зурах зургийнхаа санааг олчихсон. Гэхдээ эхэлж чадаагүй. Эхэлчих юм бол цааш нь бага багаар зураад байгаа мэдэж байгаа ч эхлүүлж чадахгүй л байна. Дараа жилийн зорилгодоо оруулаад заавал дуусгана.



1-Р ДАВХАР
ҮЙЛЧИЛГЭЭ, ОЛОН НИЙТИЙН ДАВХАР



2-Р ДАВХАР
ЗОЧИД БУУДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

QuartZ Hotel & Service Apartment

Энэхүү зочид буудлын төсөл нь орчныхоо харагдац болон нөхцөл байдалтай уялдсан өвөрмөц хэлбэр бүхий гоёмсог фасадтай ба барилгынхаа өнгө төрхөөр дамжуулан хурдны зам болон авто замаар зорчин өнгөрөх хүмүүсийн анхаарлыг татаж, хөдөлгөөний урсгалыг зочид буудал руу чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Зорин ирсэн үйлчлүүлэгчид хэрэгцээтэй үйлчилгээ болон нэгдсэн худалдааны гудамжаар үйлчлүүлэх боломжийг олгосон цогцолбор юм.

Зочид буудлын төсөл нь хөрөнгө оруулалт ихээхэн шаарддаг учир уг төслийг гурван үе шаттай барилгажих боломжтойгоор хэсэг тус бүрдээ бие даасан үйлчилгээтэй цогц төлөвлөлтийг хийж өгсөн. Ингэснээр эхний хэсэг нь бусад хэсгээс хараат бус тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжийг олгож байгаагаараа давуу талтай.



БАРИЛГЫН НЭР: THE PREMIUM HOUSE

БАЙШИЛ: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6-р хороо, Тэрэлж

ЗОРИУЛАЛТ: Амрагчийн байр

ДАВХРЫН ТОО: 2 давхар

2021 он



www.mglenc.com